ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024 ОРХОН АЙМАГ

ОРХОН АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ

# БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, СТРАТЕГИ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

**Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал**
**Ц.Наран-эрдэнэ**

# Агуулга

1. БҮСИЙН ОНОШИЛГООНЫ ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:
2. БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ, БОДЛОГО
3. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ
4. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД “НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ” БОЛГОХ САНАЛ:
5. БОЭТ-ИЙН ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

**1.1:**
Амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ

**1.2:**
Алсын хараа 2050 МУ-ын урт хугацааны бодлогын бичиг баримтын хүрээнд

**1.3:**
Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд

**1.4:**
Хөрөнгө оруулалт



# Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн өнөөгийн байдал



| Тасаг нэгж | Үзлэгийн кабинет | Эмнэлгийн ор |
|---|---|---|
| 26 | 32 | 433 |




# Амбулаторын тусламж үйлчилгээ

Сүүлийн 5 жилийн байдлаар нийт үзлэгийн тоо нэмэгдэх хандлагатай, нийт үзлэгт эзлэх урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь, идэвхитэй хяналтын хувь буурсан. 2023 оны байдлаар амбулаторит хийгдсэн нийт үзлэг өнгөрсөн оны мөн үеэс 8461-аар нэмэгдэж нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 18.1 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.8-ээр буурсан. Нийт 165006 үзлэг хийгдсэний 65.6 хувь нь эмэгтэйчүүд, 16.6 хувь нь 0-14 насны хүүхэд, 8.1 хувь нь харьяаллын бус хүмүүс үйлчлүүлсэн байна. Хүн амын өвчлөлийн бүтцийг харахад хоол шингээх, цусны эргэлт, нүд, чих хамар хоолойн, амьсгал, бөөр шээсний замын, арьс харшлийн өвчлөлүүд тэргүүлэх байранд байна.

Амбулаторит бүртгэгдсэн нийт өвчлөл 61898

- шинэ өвчин-26806
- хуучин-35092

# Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, Орны үзүүлэлт

❖ БОЭТ- нь 433 эмнэлгийн ортой, жилд дунджаар 16-18 мянга гаруй үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлдэг. 2023 оны жилийн эцсийн байдлаар 17773 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 120010 ор хоног ашигласан байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс хэвтэж эмчлүүлсэн нь 573 тохиолдлоор буурсан 17.2 хувийг /3073/ харьяаллын бус үйлчлэх хүрээний иргэд эзэлж байна.

❖ Нийт тусламж үйлчилгээний 23.7% нь мэс засал /мэс заслын 15.4% нь үе мөчний бусад, 10.5% нь цөсний хагалгаа, 8.7% нь мухар олгой, 58.5% нь хурц эмгэгээр, 41.5% нь архаг өвчнөөр хэвтэж эмийн эмчилгээ хийгдсэн байна.

## Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний орны тоо, 10 000 хүн ам




## Булган, Хөвсгөл аймгийн иргэдийн төрсөн болон хэвтэн эмчлүүлсэн тоо



# Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, Орны үзүүлэлт

❖ Хэвтэн эмчлүүлсэн тохиолдол 2020 онд урд оноос буурсан нь КОВИД-19 халдварт өвчний улмаас хөл хорио тогтоосон, иргэдийн эмнэлэгт хандалт буурсан. 2021 онд коронавируст халдвар КОВИД-19 цар тахлын улмаас ЭМС-ын тушаалаар хэвтүүлэн эмчлэх орыг нэмэлтээр баталж 2022 оны эхэн үе хүртэл үргэлжилсэн. 2022, 2023 онуудад томуу, томуу төст өвчний дэгдэлт нэмэгдэж амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөлийн хувь нэмэгдсэн.

## Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ



# НАС БАРАЛТЫН ТАЛААР

| | 2022 он | 2023 он | зөрүү | Улсын дүн |
|---|---|---|---|---|
| **Нийт нас баралт** | 542 | 487 | -55 | 17533 |
| **Эмнэлэгт нас барсан** | 95 /17.5/ | 105 /21.5/ | +10 | 31.6 |
| **Хоног болоогүй** | 36 /37.8/ | 36 /34.2/ | | 1225 /23.4/ |
| **8-24 цагийн дотор** | 20 /55.5/ | 19 /52.7/ | -1 | |
| **Хорт хавдрын нас баралт** | 8 | 6 | -2 | |
| **Гадны шалтгаан болон осол гэмтэл** | 29 | 22 | -7 | 3094 /17.6/ |



# НАС БАРАЛТЫН ТАЛААР




| БОЭТ | 2022 он | 2023 он |
|---|---|---|
| 2022 он | 38 /60.0%/ | 7 /12.2%/ |
| 2023 он | 60 /58.1%/ | 7 /14.0%/ |

Эмнэлгийн нийт нас баралтын өвчлөлийн шалтгаанаар авч үзвэл:

- Цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны
- Гадны шалтгаант осол гэмтэл
- Амьсгалын эрхтэн тогтолцооны
- Перинаталь эндэгдэл
- Хоол шингээх эрхтэн тогтолцооны
- Хавдар

Үүнээс хоног болоогүй нас баралтын 8-24 цагийн доторхи эндэгдэл:

- Тархины цус харвалт
- Уушигны хатгалгаа
- Зүрхний шигдээс
- Элэгний хатуурал
- Перинаталь эндэгдэл

8-24 цагийн доторхи нас баралтын насны бүлгийн тухайд 35-60 нас дийлэнх, хүйсийн хувьд 82.3 хувь нь эрчүүд байна. Өнгөрсөн оны мөн үеэс хоног болоогүй, 8-24 цагийн доторхи нас баралтын хувь буурсан нь зүрхний шигдээс, тархины харвалтын нэгж байгуулагдаж зүрхний шигдээс, тархины цус харвалт, элэгний хавдар, зүрхний хэм алдагдлын үед судсан доторх мэс заслын болон оношилгооны тусламж үйлчилгээг хугацаа алдалгүй үзүүлж байгаатай шууд холбоотой.

# Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого





Зорилт 1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, зүрх, судасны өвчлөлөөс болон хорт хавдраас шалтгаалсан нас баралт буурсан байна.

- Тархины цус харвалт, зүрхний шигдээсийг эрт оношилох, эмчлэх, үр дүнтэй сэргээн засах, дахихаас урьдчилан сэргийлэх, бүртгэх цогц тусламж үйлчилгээг бий болгох зорилгоор мэдрэлийн тасагт бүлэн хайлуулах эмчилгээний 2 ор, дотрын тасагт зүрхний шигдээсийн 7 ор тогтмол ажиллаж тархины цус харвалт, зүрхний шигдээсийн үеийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган үйл ажиллагааг жигдрүүлсэн.

- Зүрх судасны өвчлөлөөр нас барсан 186 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 17.5 промилл өмнөх оны мөн үеэс 0.1 промиллоор өссөн.
- Тархины цус харвалтын үеийн бүлэн хайлуулах эмчилгээг 5 тохиолдолд хийж 100% хөдөлмөрийн чадвар алдалт сэргэсэн.

- Судсан доторх оношилгоо эмчилгээнд шинэ дэвшилтэд технологиудыг ашиглан чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн. Яаралтай тусламжийн чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн.





# Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

## Зорилт 1  Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, зүрх, судасны өвчлөлөөс болон хорт хавдраас шалтгаалсан нас баралт буурсан байна.










- Жилд 220-250 орчим хавдар шинээр оношлогдож байна.
- Хавдрын өвчлөлийн  тэргүүлэх байранд:
  - элэг, ходоод,нойр булчирхай
  - хөх, умайн хүзүү, өндгөвч
  - уушиг
  - бөөр, давсаг

2022, 2023 онуудад эрт илрүүлэг үзлэгт иргэд хамрагдсанаар хавдрын өвчлөлийн эхний шатанд оношлогдож байна.

- Хавдарын шалтгаант нас баралт  жилд 140-150 орчим  тохиолддог
- 2020 онд 195, 2022 онд 183 нас бүртгэгдсэн.
- Нас баралтын  тэргүүлэх байранд:
  - элэг, ходоодны, нойр булчирхай, бүдүүн гэдэс
  - уушиг
  - умайн хүзүү, хөх, өндгөвч

Хорт хавдрын улмаас нас барсан 114 тохиолдол бүртгэгдсэн нь 10 000 хүн амд 10.7 промилл өмнөх оны мөн үеэс 19 тохиолдлоор буюу 1.8 промиллоор буурсан.09:50

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Зорилт 1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, зүрх, судасны өвчлөлөөс болон хорт хавдраас шалтгаалсан нас баралт буурсан байна.

- Хавдрын хими эмчилгээ -271
- Бай эмчилгээ 86






- ❖ Авастин,
- ❖ Герцептин,
- ❖ Вотриент,
- ❖ Капситабин,
- ❖ Кискаль гэсэн 5 төрлийн бай эмчилгээ хийж байна.

# Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

## Зорилт 2. Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буурсан байна

### Нялхасын эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд, 2023 ОН




### Амьгүй төрөлт







- 2023 оны жилийн эцсийн байдлаар нялхсын эндэгдлийн 18 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 8.0 ногдож байна. 18 тохиолдлын 13 нь тус төвд нас барсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 тохиолдлоор нэмэгдсэн.
- Нялхсын эндэгдлийн 53.8 хувь нь эрэгтэй, 46.1 хувь нь эмэгтэй ба 84.6 хувийг нярайн эндэгдэл эзэлж 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 4.9 байна.
- Нярайн эндэгдлийн нийт 11 тохиолдлын 8 буюу 72.7 хувь нь эрт үеийн эндэгдэл, 3 буюу 27.3 хувийг хожуу үеийн эндэгдэл
- Нялхсын эндэгдлийн шалтгаан: Перинаталь үеийн эмгэг 46.1, төрөлхийн хөгжлийн гажиг 23.0, бусад эрхтэн тогтолцооны эмгэг 30.7 хувь
- Нярайн эндэгдлийг эхийн тээлтийн хугацаагаар авч үзвэл: 26-28 долоо хоног 4, 32-34 долоо хоног 4, гүйцэд тээсэн 3
- Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 4.0 өмнөх оноос 0.4, улсын дунджаас 1.3 промилоор бага байна.

# Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

## Зорилт 2. Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буурсан байна







- 2023 оны жилийн эцсийн байдлаар тав хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн 21 тохиолдол бүртгэгдэж, амьд төрсөн 1000 хүүхдэд 9.4 ногдож байна.
- 21 тохиолдлын 15 нь тус төвд нас барсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 тохиолдлоор нэмэгдэж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1000 амьд төрөлтөд ноогдох тав хүртлэх насны хүүхдийн эндэгдэл 2.5 промилоор өссөн.
- Тав хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн 13 /61.9%/ эрэгтэй, 8 /3.8%/ эмэгтэй хүүхэд байна.

# ТӨРӨЛТИЙН ТАЛААР

## 3.1.1 ЭХИЙН ЭНДЭГДЭЛ, 3.1.2 ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН ЭХ БАРЬСАН ТӨРӨЛТ 2.3.3 ӨСВӨР НАСНЫ ОХИДЫН ТӨРӨЛТИЙН ТҮВШИН










| | 2022 он | 2023 он | Зөрүү |
|---|---|---|---|
| Нийт төрөлт | 2287 | 2227 | -60 |
| Төрөлтийн түвшин | 18.7 | 18.0 | -0.7 |
| Амьгүй төрөлт | 10 | 9 | -1 |
| Амьгүй төрөлтийн түвшин | 4.3 | 4.0 | -0.3 |
| Гэрийн төрөлт | 5 | 6 | +1 |
| Эмнэлгийн мэргэжилтэн эх барьсан хувь | 0.22<br>99.8 | 0.27<br>99.8 | |
| Жирэмсэний хяналтад үзүүлсэн удаа | 1281<br>56.0 | 1363<br>61.2 | |
| 2015-2020 онуудад эхийн эндэгдэлгүй ажилласан. 2021 онд эх барихын бус шалтгаант, шинэ короновируст халдварын улмаас эхийн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдсэн 2022,2023 онуудад эхийн эндэгдэлгүй ажилласан. | | | |
| Өсвөр насны охидын төрөлтийн түвшин | 82 25.5<br>у.д 22.1<br>а.д 19.7 | 54 24.3 | |

## Ойролцоо хүн ам, бусад БОЭТ-ийн төрөлт болон нас баралт

| | Нийт хүн ам | Төрсөн эх | Амьгүй төрсөн | Эхийн эндэгдэл | 100.000 амьд төрөлтөнд | Нялхасын эндэгдэл | Нас баралт | Эмнэлгийн нас баралт | Хоног болоогүй нас баралт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ховд | 91071 | 1867 | 7 | | | 23 | 395 | 67 | 12 |
| Орхон | 109125 | 2230 | 9 | | | 18 | 487 | 105 | 36 |
| Өвөрхангай | 114962 | 1960 | 5 | | | 28 | 572 | 109 | 34 |
| Хөвсгөл | 136633 | 2167 | 7 | | | 23 | 738 | 138 | 53 |
| Дархан | 107932 | 2015 | 10 | | | 16 | 491 | 91 | 25 |
| Өмнөговь | 72937 | 1400 | 11 | | | 14 | 309 | 69 | 31 |
| Дорнод | 83704 | 1507 | 10 | | | 8 | 372 | 113 | 27 |
| УБ | 1.691.766 | 34044 | 211 | 13 | 37.9 | 469 | 8428 | 3724 | 695 |

### ТӨРӨЛТИЙН ТАЛААР




*Кесар хагалгаагаар төрсөн эхчүүдийн 121 буюу 20.4 нь анхны төрөлт, үүнээс 56 тохиолдол нь 15-25 хүртэлх насны эмэгтэйчүүд байна.*

| | 2022 он | 2023 он | Зөрүү |
|---|---|---|---|
| Нийт төрөлт | 2287 | 2227 | -60 |
| Амьгүй төрөлт | 10 | 9 | -1 |
| Амьгүй төрөлтийн түвшин | 4.3 | 4.0 | -0.3 |
| Дутуу төрөлт | 138 | 101 | -37 |
| 2500 граммаас доош жинтэй төрсөн | 112 | 92 | -20 |
| Төрөлхийн гажигтай төрсөн | 29 | 22 | -7 |

2030

Эрүүл мэндийн яамнаас 2022 онд 180 сая, орон нутгийн төсвөөс 500 сая төгрөгөөр засвар хийж, улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн өртөг бүхий 34 нэр төрлийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдан 2022 оны 05 дугаар сарын 09-ны өдөр "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийн үйл ажиллагааг эхлүүлсэн.

ЭМДТ-р тайлант хугацаанд нийт 9047үйлчлүүлэгчийг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Улаан хоолой ба ходоодны дуранд нийт 4350 иргэн хамрагдсан. Үүнээс
406 хүнд эдийн шинжилгээ хийж 1-р үеийн хавдар 22
2-р үеийн хавдар 5
2-3-р үеийн хавдар 5
2-4-р үеийн хавдар 2
3-4-р үеийн хавдар 1-ийг тус тус илрүүлсэн

2030

Алсын хараа 2050 МУ-ын урт хугацааны бодлогын бичиг баримтын хүрээнд





Зорилт 1.Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана

# Алсын хараа 2050 МУ-ын урт хугацааны бодлогын бичиг баримтын хүрээнд

**Зорилт 4. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.**




## СҮРЬЕЭГИЙН ӨВЧЛӨЛИЙН ТҮВШИН

10 000 хүн амд 14.4

| Сүрьеэгийн хэлбэр | | Шинэ бүртгэгдсэн | | Тайлангийн эцэст хяналтад байгаа | |
|---|---|---|---|---|---|
| | | Бүгд | Хүүхэд /0-15/ | Бүгд | Хүүхэд /0-15/ |
| А | | 1 | 2 | 3 | 4 |
| Уушгины сүрьеэ | Бүгд | 45 | | 25 | |
| | Нэвчдэст | 30 | | 21 | |
| | Голомтот | 1 | | | |
| | Хурц тархмал | 1 | | | |
| | Хөндийт | 9 | | 2 | |
| | Сорвит хөндийт | 3 | | 2 | |
| | Туберкулём | | | | |
| | Бусад | 1 | | | |
| Уушгины бус сүрьеэ | Бүгд | 20 | 4 | 8 | 1 |
| | Уушгины угийн булчирхайн | 3 | 3 | | |
| | Уушгины гялтан хальсны | 3 | 1 | 1 | 1 |
| | Нурууны | 2 | | 2 | |
| | Яс, үений | 1 | | | |
| | Гэдэс, хэвлийн эрхтний | 3 | | 2 | |
| | Захын тунгалгийн булчирхайн | 5 | | 2 | |
| | Бусад | 3 | | 1 | |
| Нийт | | 65 | 4 | 33 | 1 |

## Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд:

ЭМДЕГ-тай 419 оношийн хамааралтай бүлгээр гэрээлж нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг бүрэн үзүүлэх, шаардлагагүй хэвтэлт, үр ашиггүй тусламж, үйлчилгээг бууруулах, төвлөрлийг саарулах, иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилго тавин ажиллаж байна.






# Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд  гарсан эерэг өөрчлөлтүүд



Үйлчлүүлэгчийн ая тухтай орчин  бүрдсэн

Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын төсөв

Цалин



30 ажилтан - 600сая











# ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛ /2018-2023 он/

| ОН | 2018 | | 2019 | | 2020 | | 2021 | | 2022 | | 2023 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ОНХ | Улсын төсөв/ЭМЯ/ | ОНХ | Улсын төсөв/ЭМЯ/ | ОНХ | Улсын төсөв/ЭМЯ/ | ОНХО | Улсын төсөв/ЭМЯ/ | ОНХ | Улсын төсөв/ЭМЯ/ | ОНХ | Улсын төсөв/ЭМЯ/ |
| Нийлүүлсэн тоо ширхэг | 81 | 2 | 55 | 3 | 56 | 13 | 141 | 96 | 34 | 207 | 5 | 7 |
| Санхүүжилтын эх үүсгэвэр | 188,271,625 | 44,515,390.00 | 173987510 | 299575972 | 879,831,518.00 | 4,856,484,735.25 | 1,532,196,480.00 | 2,799,779,601.99 | 297,205,000.00 | 1,443,818,562.00 | 48,628,100.00 | 919,747,258.00 |
| Нийт санхүүжилт | 232,787,015.00 | | 473,563,482.00 | | 5,736,316,253.25 | | 4,331,976,081.99 | | 1,741,023,562.00 | | 968,375,358.00 | |







2021-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны

# СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Зорилт | Бүлэг | Үйл ажиллагаа |
|---|---|---|
| 5 | 13 | 64 |

Стратегийн тэргүүлэх чиглэл 1: Эмнэлэгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг улсын жишигт хүргэх

Стратегийн тэргүүлэх чиглэл 2: Хүн төвтэй нийгмийн эрүүл мэндийн тусламжийг бүс нутгийн хэмжээнд манлайлах

Стратегийн тэргүүлэх чиглэл 3: Олон улсын төвшинд хүрсэн чадавхтай хүний нөөцийн хөгжлийг тогтвортой хангах

Стратегийн тэргүүлэх чиглэл 5: Эмнэлгийн бие даасан байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах

Стратегийн тэргүүлэх чиглэл 4: Эрүүл мэндийн тэргүүлэх технологийн хөгжлөөр хүн амын эрүүл мэнд сайн сайхан байдалд нөлөөлөх














# СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ












# Стратегийн тэргүүлэх чиглэл 1: Эмнэлэгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг улсын жишигт хүргэх

**2022**

Дурангийн мэс заслын нэр төрөл хүртээмжийг нэмэгдүүлэх.

- Хэвлийн хөндий дуран
- Цээжний хөндий дуран
- Эмэгтэйчүүдийн дуран

**2022**

Төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

- Чих хамар хоолой, нүд, эрүү нүүрний мэс заслын тусламж үйлчилгээг төрөлжүүлэн өргөжүүлэх.
- Хавдрын тусламж үйл ажиллагааг өргөжүүлж, эрт илрүүлэг болон мэс заслын тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх.
- Бүдүүн шулуун гэдэсний орчин үеийн дэвшилтэт мэс заслын аргуудыг нэвтрүүлэх.

**2022**

Сүүлийн үеийн өндөр хүчин чадалтай оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах.

- Нярайн скрининг оношилгоог өргөжүүлэх, хөгжүүлэх.
- Мэс засал болон мэс заслын дараах өрөөнүүдийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр хангах.
- Лавлагаа тусламжийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлзүйн лабораторийн оношилгоо, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх.

# Зорилт 1.4: Тусламж үйлчилгээний чанар өвчтөний аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах.

2022

1.3.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг удирдлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох




2022

1.3.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх.

## Зорилт 3.4: Сайн эмчийг бэлтгэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

**2022**



3.4.1. Төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалт эрхлэх эмнэлгийн сүлжээг улсын төв эмнэлэгтэй ижил түвшний сургалт эрхлэх байгууллага бий болгож, хамтарсан сургалт эрхлэх.

3.4.2. Төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалтын нэгжийн чадавхийг сайжруулах, олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.

3.4.3. Төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалтанд багшлах эмнэлзүйн сургагч багш-эмчийн эзлэх хувийг нэмэгдүүлж ажиллах.

3.4.4. Эмнэлзүйн ур чадварын төвийн сургалтын орчинг бэхжүүлж эмч, эмнэлгийн мэргэжлийн ур чадварыг тогтмол сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх.

# Тулгамдаж буй асуудал

Амбулаторийн өвчний учир үзлэгийн тэргүүлэх чиглэлд:

**Нэг.** Амбулаторит өвчний учир үзүүлэх үзлэгийн тоо жил ирэх тусам өсч байгаа нь хүн амын эрүүл мэндийн түвшин буурч, иргэдийн эрүүл мэндийн боловсрол дутмаг байгааг илэрхийлж байна.

Дотрын өвчин
/10.000 хүн амд 2531буюу 25.3%/
**26833**

Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин
**16103**

Бөөр
**9779**

Мэдрэлийн эмгэг
**10930**

Чих хамар хоолойн өвчин
**11139**

# Тулгамдаж буй асуудал

**Хоёр.** Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ 2023 онд 17773, үүнээс харъяалалын бус 3073, 14700 буюу 10.000 хүн амд-1387, нийт 14% нь хэвтэж эмчлүүлсэн.



# Тулгамдаж буй асуудал

**Гурав.** Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл 2023 оны байдлаар 1947 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөнд 872 ногдож байна.

Жирэмсний 6 ба түүнээс дээш үзлэг
64.6

Жирэмсэн үеийн хүндрэл
55.0

Төрөх үеийн хүндрэл
44.2

Жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл
0.8

Жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл
8.3

Төрөлт буурч байгаа боловч нялхасын эндэгдэл, нярайн эндэгдэл өсөх хандлагатай
0.8



# Тулгамдаж буй асуудал:

**04** Антибиотект тэсвэртэй стафиллококын халдвар MRSA нь хүн амын дунд тархмал байгаа нь үйлчилгээний ажилчдын урьдчилан сэргийлэх шинжилгээ, /9-10%/, хэвтэн эмчлүүлэгсдийн дотор 2023 онд 52 тохиолдол бүртгэгдсэн зэргээс харагдаж байна.

**05** Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт хангалтгүй, өвчлөл илэрсэн тохиолдолд хяналтад авах, эмчилж эрүүлжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааны тогтолцоо сул.

**06** Халдварт өвчнийг тандах, мэдээлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаарх тушаал шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй. Ялангуяа суулгалт халдваруудыг тандах, мэдээлэх, эмчилж эрүүлжүүлэх чиглэлээр удирдлага зохион байгуулалтаар хангагдах, мэргэжил аргазүйн зөвлөмж авах хэрэгцээ шаардлага үүссэн.

**07** Аймгийн хэмжээнд яаралтай тусламж үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй.

**08** БОЭТ-ийн барилга байгууламжийн насжилт өндөр, ашиглалтын явцад сантехник, агааржуулалт, дээврийн элэгдэл, эвдрэл үүсч зарим тасаг нэгжүүдэд асуудал үүсч байна.

## Аймгийн хэмжээнд “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох санал:

## Анхан шатны тусламж үйлчилгээнд:

Хүн амын эрүүл мэндийн бүлгийг бодитой үнэлэх, иргэдийн ЭМБ-ыг дээшлүүлэх арга хэмжээг эрчимтэй зохион байгуулах.

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, охидын эрүүл мэндийг хамгаалах дэмжих, гэр бүл төлөвлөлтийг зөв зохистой зохицуулах замаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл, нялхасын эндэгдэл, тав хүртлэх насны хүүхдийн эндэгдэл, төрөлхийн гажиг, эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчнийг бууруулах

Хүн амын дунд “Эрүүл амьдралын хэв маяг”-ийг сурталчилах, төлөвшүүлэх замаар зонхилон тохиолдох халдварт бус өвчин тэр дундаа цусны эргэлтийн эрхтэн тогтолцоо, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчлөлийн анхдагч суурь болох стресс, артерийн гипертензи, архи , тамхи, нойргүйдэл, илүүдэл жингийн асуудлыг зохицуулж хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааны бууруулах.

Анхан шатанд диспансерийн хяналтыг сайжруулж өвчнийг архагшуулахгүй байх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах

## Аймгийн хэмжээнд “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох санал:

### Бусийн оношилгоо эмчилгээний түвшинд:

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг чанартай зохион байгуулж хяналтад авах эмчилж эрүүлжүүлэх, тогтолцоог бэхжүүлэх.

Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын идэвхитэй хяналтын хувийг нэмэгдүүлэх, сайжруулах.

Аймгийн хэмжээнд "Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох санал:

Эрүүл мэндийн газрын түвшинд:

Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа ЗСӨ, артерийн даралт ихсэх өвчний шалтгааныг бууруулахад чиглэсэн сургалт, анхан шатны хяналт тусламж үйлчилгээг аль болох бага наснаас эхлэн үзүүлж, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах бодлого боловсруулж хамтран ажиллах /жингийн илүүдэл, хөдөлгөөний хомсдол, хүнсний аюулгүй байдал зохисгүй хэрэглээ, стресс, хорт зуршил, дэлгэцийн хамаарал/.

Аймгийн хэмжээнд "Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж өвчлөл илэрсэн тохиолдолд хяналтад авах, эмчилж эрүүлжүүлэх тогтолцоог бэхжүүлэх, хяналт тавих.

Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж буй эрүүл мэндийн байгууллагуудын ачааллыг тэнцвэржүүлэх, ЭМБ бүр эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах төлөвлөгөө батлуулах.

Хүн амын дунд зонхилон тохиолдож, сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байгаа халдварт өвчнүүдийн илрүүлэг, тандалт судалгаа шинжилгээг эрсдэлт бүлгийн хүн амд бүх шатны эрүүл мэндийн байгууллагын оролцоотойгоор богино хугацаанд хийж хяналтад авах, тархалтыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж хожмын эрсдлээс сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх /БЗХӨ, сүүлгалт халдварууд, сүрьеэ/.

Аймгийн хэмжээнд антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх.

# Бусийн оношилгоо эмчилгээний төвийн цаашдын чиг хандлага /2024-2027/



1. Нэн шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхийг бэхжүүлэх /Хорт хавдар хими, бай, хөнгөвчлөх, хавдрын мэс засал, гэмтлийн яаралтай тусламж, гэмтлийн мэс засал, яаралтай тусламж/
2. Төвлөрлийг сааруулах бодлого барьж иргэдийг санхүүгийн эрсдлээс хамгаалах
3. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг чанартай зохион байгуулж хяналтад авах эмчилж эрүүлжүүлэх, тогтолцоог бэхжүүлэх
4. Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын идэвхитэй хяналтын хувийг нэмэгдүүлэх, сайжруулах
5. Нөхөн сэргээх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээг өргөжүүлэх

# Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн цаашдын чиг хандлага /2024-2027/



6. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих албатай болох
7. Эрүүл мэндийн салбарт хийгдэж буй цахим шинэчлэлтийг дэмжиж байгууллагын сүлжээ, сервер, программын хөгжүүлэлтэд технологийн шинэчлэл хийх
8. Хагалгааны өрөөг ваакумжуулах
9. Яаралтай тусламжийн нэгдсэн төв байгуулах
10. Ажиллагсдын нийгмийн баталгаа, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх

# Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн цаашдын чиг хандлага /2028-2030/

Хавдрын тусламж үйлчилгээний цогц төв байгуулах



Перинаталоги  төвтэй болох

Зүрхний хэм алдагдлын төрөлжсөн кат-лаб өрөөг байгуулж, тусламж үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх



# БАЯРЛАЛАА...